



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар Д/195

Улаанбаатар хот


**Нийслэлийн Цагдаагийн газрын
данс бүртгэлээс тээврийн
хэрэгсэл хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан 23,600,000.0 /хорин гурван сая зургаан зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан 2 тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/-т тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ